



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 124

Хужирт сум

Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны
цэцэг Өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Бог малын гоц халдварт цэцэг өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" 03 дугаар албан даалгавар, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, цэцэг өвчний яаралтай дархлаажуулалтад ажиллах хүн хүч, шатахуун, бусад зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг ажлыг хэсэг (Б.Дэмбэрэл), малчин, мал бүхий иргэдэд мэдээлж, тархвар зүйн судалгаанд үндэслэн малыг бүрэн хамруулахад анхаарч ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажилд шаардагдах зардлыг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй

5. Гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хяналт тавьж ажиллан, үр дүнг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТБАЯР

622401047

D.Alban bichig,Zahiramj 2024